# СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

## ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа цахим шуудангаар ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- Төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- Зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- Зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

Бүрдүүлэх материал:

- Төрийн албан хаагчийн анкет;
- Иргэний үнэмлэхний хуулбар;
- Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
- Нийгмийн даатгалын цахим лавлагаа;
- Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар;
- Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар;
- Сүүлийн 1 жилийн төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн мэргэшлийн түвшинг үнэлсэн илтгэх хуудас, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээ;
- Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia-аас татан авах/

Материал хүлээн авах:

Хугацаа: 2024 оны 09 дугаар сарын 18-ны өдрийн 08:00 цагаас 09 дугаар сарын 24-ний өдрийн 17:00 цаг хүртэл

Хүлээн авах хаяг: Songinohairhan@ndaatgal.mn цахим шуудангаар хүлээн авна.

Холбоо барих утас: 70173259 88078833

# ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭХ, СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

**БАЙГУУЛЛАГЫН НЭР: СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР**

2024 оны 09 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

| д/д | Байгууллагын нэр | Нэгжийн нэр | Албан тушаалын | | Хариуцах асуудал | Орон тоо | Албан тушаалд тавигдах тусгай шаардлага | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ангилал | Нэр | | | Боловсрол | Мэргэжил | Мэргэшил | Туршлага | Ур чадвар |
| 1 | Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газар | Хамралт, орлогын хэлтэс | Дэс түшмэл ТЗ-8 | Сайн дурын даатгалын байцаагч, мэргэжилтэн | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх, зорилтот бүлгийн иргэдийг сайн дурын даатгалд хамруулах, хамралтыг нэмэгдүүлэх, даатгуулагчдын мэдээллийн санг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна. | 1 | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх | Эдийн засаг /0311/, Нягтлан бодлох бүртгэл, татвар /0411/ Санхүү, банк, даатгал /0412/ Маркетенг, зар сурталчилгаа /0414/ Худалдаа /0416/, менежмент ба удирдахуй /0413/ | - | Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно. | Дүн шинжилгээ хийх; Асуудал шийдвэрлэх; Багаар ажиллах; Бусад. |
| 2 | Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газар | Санхүү бүртгэлийн хэлтэс | Дэс түшмэл ТЗ-8 | Сангийн бүртгэл хариуцсан мэргэжилтэн | Нийгмийн даатгалын сангийн төлөвлөгөөг хангах, сангийн орлого, зарлагыг нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн санд бүртгэх, тайлан мэдээ гаргах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна. | 1 | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх | Эдийн засаг /031/, Нягтлан бодлох бүртгэл, татвар /0411/ Санхүү, банк, даатгал /0412/ , бизнесийн удирдлага /041301/ | - | Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно. | Дүн шинжилгээ хийх; Асуудал шийдвэрлэх; Багаар ажиллах; Бусад. |
| 3 | Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газар | Нэг цэгийн үйлчилгээ, цахим мэдээллийн тасаг | Дэс түшмэл ТЗ-8 | Цахим үйлчилгээ хариуцсан байцаагч, мэргэжилтэн | Нийгмийн даатгалын үйлчилгээг цахимаар болон үүрэн холбооны хэрэгслээр цаг алдалгүй хурдан шуурхай хүргэх, нийгмийн даатгалын тухай багц хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг сурталчлах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна. | 1 | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх | багш, мэдээлэл зүйн боловсрол /011403/, Эдийн засаг /031/, социологи болог соёл судлал /0314/, Нягтлан бодлох бүртгэл, татвар /0411/ Санхүү, банк, даатгал /0412/ Маркетенг, зар сурталчилгаа /0414/ , эрх зүй /0421/, менежмент ба удирдахуй /0413/ , математик /0541/, өгөгдлийн сан, сүлжээний загварчлал /дизайн/ ба удирдлага /0612/, программ хангамж, түүний хэрэглээ хөгжүүлэлт ба шинжилгээ /0613/ | - | Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно. | Дүн шинжилгээ хийх; Асуудал шийдвэрлэх; Багаар ажиллах; Бусад. |
| 4 | Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын газар | Баянхошуу дахь нийгмийн даатгалын хэлтэс | Дэс түшмэл ТЗ-8 | Нэг цэгийн үйлчилгээний байцаагч, мэргэжилтэн | Нийгмийн даатгалын хууль тогтоомж болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, зөвлөгөө мэдээлэл өгөх, тэтгэвэр, тэтгэмжийн баримтыг цаг хугацаанд нь хүлээн авах, хүсэлт илгээх чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг хэлтсийн даргын өмнө хариуцна. | 2 | Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх | Эдийн засаг /0311/, Нягтлан бодлох бүртгэл, татвар /0411/ Санхүү, банк, даатгал /0412/ , менежмент ба удирдахуй /0413/ Маркетенг, зар сурталчилгаа /0414/ Худалдаа /0416/, эрх зүй /0421/ | - | Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно. | Дүн шинжилгээ хийх; Асуудал шийдвэрлэх; Багаар ажиллах; Бусад. |